



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРОО



МОНГОЛ УЛСЫН ХӨГЖИЛ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД

ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

2020 он



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖИЛ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Улаанбаатар
2020 он

Боловсруулсан:

Б.Гэрэл

ҮСХ-ны ҮТШСГ-ын статистикч

Хянасан:

Ч.Баянчимэг

ҮСХ-ны дэд дарга

А.Дэмбэрэл

ҮСХ-ны ҮТШСГ-ын дарга

Н.Өлзийханд

ҮСХ-ны ҮТШСГ-ын ахлах статистикч

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44

Засгийн газрын III байр

Утас: (976-11)-326414, 1900-1212

Факс: (976-11)-324518

Цахим хуудас: <http://nso.mn>, www.1212.mn

И-мэйл: information@nso.mn

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ОРШИЛ.....	7
НЭГ. МОНГОЛ ХҮНИЙ ХӨГЖИЛ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД.....	8
1.1. МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	8
1.2. МОНГОЛ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКСИЙН ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛАЛТ.....	10
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД	12
2.1. НЭГ ХҮНД НОГДОХ ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО	13
2.2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, БҮТЭЦ.....	15
2.3. ИНФЛЯЦ.....	20
2.4. УЛСЫН ТӨСӨВ, ГАДААД ӨР.....	22
2.5. ГАДААД ХУДАЛДАА.....	25
ДҮГНЭЛТ.....	30

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хүний хөгжлийн бүрэлдэхүүн индекс, 2011-2019.....	8
Хүснэгт 2. Хүний хөгжлийн индекс, хүний хөгжлийн үндсэн үзүүлэлт, 2018	11
Хүснэгт 3. Үндэсний нийт орлого, тэрбум ам.доллар, 2010-2019 он.....	13
Хүснэгт 4. Нэг хүнд ногдох ҮНО, Дэлхийн банкны атласын аргаар, ам.доллар, 2010-2019 он	14
Хүснэгт 5. ДНБ-ий өсөлт, бууралт, хувиар, 2010-2019 он	16
Хүснэгт 6. Гадаад өрийн хэмжээ, тэрбум ам.доллар, 2010-2018 он.....	23
Хүснэгт 7. ҮНО ба Гадаад өрийн харьцаа, хувиар, 2010-2018 он	24
Хүснэгт 8. Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт, импорт, экспорт, тив, улс орноор, сая ам.доллар, 2010-2019 он	27

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Монгол Улсын хүний хөгжлийн индекс, 2011-2019	8
Зураг 2. ХХИ бүрэлдэхүүн индекс, бүсээр, 2019 он	9
Зураг 3. Монгол Улсын хүний хөгжлийн индекс, аймаг, нийслэлээр 2019	9
Зураг 4. Дэлхийн хүний хөгжлийн индекс, 2018	10
Зураг 5. Дэлхийн ХХИ, Монгол Улсын ХХИ, хүний хөгжлийн бүлгээр, 2018	11
Зураг 6. Нэг хүнд ногдох ҮНО-оор болон ХХИ-ээр эзлэх байр, 2019.....	12
Зураг 7. Нэг хүнд ногдох ҮНО, Дэлхийн банкны атласын аргаар, ам.доллар, 2010-2019 он	15
Зураг 8. ДНБ-ий жилийн өсөлт, бууралт	16
Зураг 9. ДНБ-ий салбарын бүтэц, дүнд эзлэх хувиар, 2010 он.....	17
Зураг 10. ДНБ-ий салбарын бүтэц, дүнд эзлэх хувиар, 2019 он.....	17
Зураг 11. Эдийн засгийн голлох салбарын НӨ-ийн өсөлт, бууралт, сонгогдсон улсаар	19
Зураг 12. Инфляцын түвшин, хувиар, 2010-2019 он.....	20
Зураг 13. Инфляцын түвшин, сонгогдсон улсуудаар, хувиар, 2010-2019 он	21
Зураг 14. Улсын төсвийн орлогын (тусламжийг оруулаагүй) ДНБ-д эзлэх хувь, 2010-2018 он	22
Зураг 15. Улсын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь, 2010-2018 он	22
Зураг 16. Гадаад өр ба экспортын харьцаа, хувиар, 2010-2018 он.....	25
Зураг 17. Монгол Улсын экспорт, импорт, тэнцэл, тэрбум америк доллароор, 2010-2019 он	25
Зураг 17. Бүс нутгийн эдийн засгийн интеграцийн дэлхийн газрын зураг, 2020 он.....	28
Зураг 18. ХАА-н бараа, бүтээгдэхүүний тариф	29
Зураг 19. Аж үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний тариф.....	29

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДБ	Дэлхийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДХБ	Дэлхийн Худалдааны Байгууллага
ЗАНДБН	Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг
НӨ	Нэмэгдэл өртөг
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НҮБХХ	Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ОУВС	Олон улсын валютын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ХАА	Хөдөө аж ахуй
ХХИ	Хүний хөгжлийн индекс
ЧХХ	Чөлөөт худалдааны хэлэлцээр
ҮНО	Үндэсний нийт орлого
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

ОРШИЛ

Дэлхийн банкнаас жил бүр улс, орнуудыг нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын хэмжээнээс нь хамааруулан бага орлоготой, дунд орлоготой (дундаас доогуур болон дундаас дээгүүр), өндөр орлоготой гэж ангилдаг. Мөн Нэгдсэн үндэсний байгууллагаас дэлхийн улс орнуудыг хүний хөгжлийн индексээр нь хүний хөгжлөөр нэн өндөр, өндөр, дундаж, бага гэж ангилдаг.

Энэхүү судалгааны ажил нь Монгол Улсын хөгжлийг дэлхийн улс орнуудтай харьцуулахдаа дээр дурдсан ангиллаар нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг харьцуулан харуулахад чиглэсэн.

Манай улс нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын хэмжээгээр 2019 онд 124 дүгээр байрт эрэмбэлэгдэж, 2015 оноос 17 байраар урагшилсан хэдий ч хүний хөгжлийн индексээр 92 дугаарт эрэмбэлэгдэж, 2 байраар ухарсан байна.

Хөгжлийн тэгш бус байдлыг бууруулахад дунд, урт хугацаанд эдийн засгийг идэвхжүүлж, тогтвортой хөгжлийг хангах нь нэн чухал бөгөөд далайд гарцгүй, хоёр их гүрний дунд орших манай орны хувьд бүс нутаг, хөрш зэргэлдээ орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг судлах нь чухал юм.

Уг судалгааны өгөгдөл нь ҮСХ-ноос гаргаж байгаа албан ёсны статистикийн мэдээлэл, Дэлхийн банкнаас эрхлэн гаргадаг “Дэлхийн хөгжлийн үзүүлэлт”-2019, Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрөөс эрхлэн гаргадаг “Хүний хөгжлийн илтгэл”-2019 зэрэг баримт бичигт тусгагдсан мэдээлэлд суурилсан.


НЭГ. МОНГОЛ ХҮНИЙ ХӨГЖИЛ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД

1.1. МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Сүүлийн үед дэлхий нийтээрээ хөгжлийн түвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас зайлсхийж, хүний хөгжлийн асуудалд онцгой анхаарал хандуулж байна. Улс үндэстний гол баялаг, хөгжлийн хүч, ирээдүйг тодорхойлогч үнэт зүйл бол хүн өөрөө байдаг. Хүний хөгжил гэдэг бол товчхондоо хүн төвтэй хөгжил - үйл явц хийгээд үр дүн юм. Өөрөөр хэлбэл, хүмүүсийг хөгжүүлэх, хөгжлийг хүмүүст зориулах, хүмүүсийн өөрсдийнх нь оролцоотойгоор хөгжлийг хангана гэсэн үг.

Монгол Улсын хүний хөгжлийн индекс 2011 онд 0.709 байсан бөгөөд тасралтгүй өссөөр 2019 оны гүйцэтгэлээр 0.744 болж, 0.035 нэгжээр нэмэгдсэн байна.

Зураг 1. Монгол Улсын хүний хөгжлийн индекс, 2011-2019 он



Манай улсын хүн амын дундаж наслалт 2011-2019 онд 2.1 жилээр, сургуульд суралцах хугацаа 5.3 жилээр, сургуульд суралцахаар хүлээгдэж буй хугацаа 0.2 жилээр, нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 62.4 хувиар нэмэгдсэн байна.

Хүний хөгжлийн бүрэлдэхүүн индексийн хүн амын боловсролын түвшний индекс 2011 онд 0.721 байсан бол 2019 онд 0.726 болж 0.005 нэгжээр, дундаж наслалтын индекс 2011 онд 0.743 байсан бол 2019 онд 0.776 болж 0.033, харин нэг хүнд ногдох ҮНО-ын индекс 2011 онд 0.664 байсан бол 2019 онд 0.732 болж 0.068 нэгжээр тус тус өссөн байна. Сүүлийн 9 жилийн хугацааг харахад хүн амын дундаж наслалт, нэг хүнд ногдох ҮНО-ын индексийн өндөр өсөлтөөс шалтгаалж, хүний хөгжлийн индекс нэмэгдсэн байна. Харин боловсролын индекс 2014 оноос буурсаар 2018 онд 0.721 болж, 0.016 нэгжээр буурсан бол 2019 онд 2018 оноос 0.005 нэгжээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Хүний хөгжлийн бүрэлдэхүүн индекс, 2011-2019 он

	Хүн амын дундаж наслалтын индекс	Хүн амын боловсролын түвшний индекс	Нэг хүнд ногдох ҮНО-ын индекс	Хүний хөгжлийн индекс
2011	0.743	0.721	0.664	0.709
2012	0.749	0.726	0.682	0.718
2013	0.756	0.724	0.701	0.726
2014	0.763	0.737	0.708	0.735
2015	0.768	0.732	0.710	0.736
2016	0.763	0.728	0.710	0.733
2017	0.768	0.722	0.708	0.732
2018	0.772	0.721	0.726	0.739
2019	0.776	0.726	0.732	0.744


ХХИ бүрэлдэхүүн индексийг бүсээр авч үзэхэд:

Хүн амын дундаж наслалтын индекс Төвийн бүсэд хамгийн өндөр 0.804 (72.26 жил), Улаанбаатарт 0.797 (71.8 жил), Зүүн бүсэд 0.797 (71.8 жил), Баруун бүсэд 0.791 (71.40 жил), Хангайн бүсэд 0.784 (70.95 жил) байна.

Боловсролын индекс хамгийн өндөр нь Улаанбаатар 0.870 (сургуульд суралцсан хугацаа 11.11 жил, сургуульд суралцахаар хүлээгдэж буй хугацаа 18.45 жил), Төвийн бүсэд 0.643, Зүүн бүсэд 0.608, Баруун бүсэд 0.604, Хангайн бүсэд 0.599 байна.


Орлогын индексээр хамгийн өндөр нь Улаанбаатар (0.804) улсын дунджаас 0.072 нэгжээр дээгүүр байхад Зүүн бүс (0.721), Хангайн бүс (0.697), Төвийн бүс (0.675), Баруун бүс (0.620) улсын дунджаас 0.011-0.112 нэгжээр доогуур байна

Зураг 2. ХХИ бүрэлдэхүүн индекс, бүсээр, 2019 он



Монгол Улсын хүний хөгжлийн индекс 2019 оны гүйцэтгэлээр аймаг, нийслэлийн түвшинд авч үзэхэд хамгийн өндөр нь Улаанбаатар 0.823 улсын дунджаас 0.079 нэгжээр дээгүүр, Орхон 0.783, Дорнод 0.726, Говьсүмбэр 0.717 байна. Харин Хөвсгөл 0.645, Өвөрхангай 0.648, Увс 0.653, Баян-Өлгий 0.657, Баянхонгор 0.659 аймгууд улсын дунджаас 0.085-0.099 нэгжээр доогуур байна. Ихэнх аймгуудын хүний хөгжлийн индекс улсын дунджаас жигд доогуур байгаа бөгөөд Улаанбаатар хотынх өндөр байгаа нь нийт хүн амын хагас, ДНБ-ий 66.4 хувь, ЕБС, их, дээд сургууль, коллежийн ихэнх хувь нь байрлаж байгаатай холбогдож байна.

Зураг 3. Монгол Улсын хүний хөгжлийн индекс, аймаг, нийслэлээр 2019 он




1.2. МОНГОЛ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКСИЙН ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛАЛТ

Дэлхийн улс орнуудын хөгжлийн түвшнийг харуулах гол үзүүлэлт бол хүний хөгжлийн индекс юм. Хүний хөгжлийн индекс (ХХИ) нь хүний чадавхын хөгжлийг харуулах бөгөөд эрүүл саруул байж, урт удаан наслах; эрдэм мэдлэг эзэмших; амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх гэсэн хүний амьдралын үндсэн гурван хэмжигдэхүүнийг илэрхийлдэг.

НҮБ-аас эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд хүний хөгжил улам бүр чухал болж байгааг тодорхойлох зорилгоор үндэсний хүний хөгжлийн илтгэлийг гаргаж байхыг гишүүн орнууддаа уриалсан ба НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) дэлхийн хүний хөгжлийн анхны илтгэлээ 1990 онд боловсруулж байсан.

Дэлхийн улс орнуудыг ХХИ-ээр нь дээд (very high), дээгүүр (high), дундаж (medium), доогуур (low) хүний хөгжилтэй гэж зэрэглэн ангилдаг.

Зураг 4. Дэлхийн хүний хөгжлийн индекс, 2018 он



НҮБХХ-өөс гаргасан дэлхийн ХХИ-ийн үзүүлэлтийн 2019 оны тайлангаар нийт 189 орны 59 нь хүний хөгжлөөр нэн өндөр (very high) бүлэгт, 53 нь өндөр (high), 39 нь дунд (medium), 38 нь хүний хөгжлөөр бага (low) бүлэгт ангилагдсан байна.

Манай улсын ХХИ сүүлийн жилүүдэд үндэсний болон бүс нутгийн хэмжээнд жил дараалан тасралтгүй өссөөр, дэлхийд ХХИ-ээрээ 189 орноос

92-т эрэмбэлэгдэж, хүний хөгжлөөр өндөр түвшний орнуудын ангилалд багтаж байна.


“Хүний хөгжлийн илтгэл 2011”-д Монгол Улс хүний хөгжлийн индексээрээ 110 дугаар байранд байсан бол “Хүний хөгжлийн илтгэл 2019”-д 92 дугаар байранд орж, 18 байраар урагшилжээ.

НҮБХХ-өөс гаргасан тооцоогоор манай улсын ХХИ 2018 онд 0.735 нэгж болж, дэлхийн ХХИ-ээс 0.004 нэгжээр, хүний хөгжлөөр дундаж үзүүлэлттэй орнуудын дунджаас 0.101 нэгжээр, хүний хөгжлөөр доогуур үзүүлэлттэй орнуудын дунджаас 0.228 нэгжээр өндөр байгаа бол хүний хөгжлөөр өндөр үзүүлэлттэй орнуудын дунджаас 0.015 нэгжээр, хүний хөгжлөөр нэн өндөр үзүүлэлттэй орнуудын дунджаас 0.157 нэгжээр доогуур байна.¹

¹ [НҮБХХ-ийн тооцоо](#)

Дэлхийн ХХИ 2018 онд өмнөх оноос 0.003 нэгжээр нэмэгдсэн бол хүний хөгжлөөр өндөр үзүүлэлттэй орнуудынх 0.007 нэгжээр буурсан байна. Монгол Улсын ХХИ 2018 онд өмнөх онтой харьцуулахад 0.006 нэгжээр буурсан байна.

Зураг 5. Дэлхийн ХХИ, Монгол Улсын ХХИ, хүний хөгжлийн бүлгээр, 2018 он



Эх үүсвэр: [НҮБХХ “Хүний хөгжлийн илтгэл 2019”](#)

Монгол хүний дундаж наслалт 2018 оны байдлаар 69.7 жил байна. Энэ нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг (ЗАНДБН)-ийн орнуудаас 5.6 жилээр, хүний хөгжлийн нэн өндөр үзүүлэлттэй орнуудаас 9.8 жилээр, хүний хөгжлийн өндөр үзүүлэлттэй орнуудаас 5.4 жилээр бага, хүний хөгжлийн дундаж үзүүлэлттэй орнуудаас 0.4 жилээр их байна.

Сургуульд суралцах дундаж хугацаа 14.2 жил байгаа нь ЗАНДБН-ийн орнуудаас 0.8 жилээр, хүний хөгжлийн өндөр үзүүлэлттэй орнуудаас 0.4 жилээр, хүний хөгжлийн дундаж үзүүлэлттэй орнуудаас 2.5 жилээр илүү, хүний хөгжлийн нэн өндөр үзүүлэлттэй орнуудаас 2.2 жилээр бага байна.

Харин сургуульд суралцсан дундаж жил 10.2 жил байгаа нь ЗАНДБН-ийн орнуудаас 2.3 жилээр, хүний хөгжлийн өндөр үзүүлэлттэй орнуудаас 1.9 жилээр, хүний хөгжлийн дундаж үзүүлэлттэй орнуудаас 3.8 жилээр илүү, хүний хөгжлийн нэн өндөр үзүүлэлттэй орнуудаас 1.8 жилээр бага байна.

Хүний хөгжлийн гол үзүүлэлтүүдийн нэг болох нэг хүнд ногдох ҮНО 2018 онд 10784 ам.доллар болж өнгөрсөн жилээс 6.7 хувиар өссөн хэдий ч хүний хөгжлөөр ижил бүлгийн орнуудаас 25.1 хувиар, ЗАНДБН-ийн орнуудаас 26.2 хувиар, хүний хөгжлөөр нэн өндөр орнуудаас 3.7 дахин бага орлоготой байна.

Хүснэгт 2. Хүний хөгжлийн индекс, хүний хөгжлийн үндсэн үзүүлэлт, 2018 он

	ХХИ	Дундаж наслалт /жил/	Сургуульд суралцах хугацаа /жил/	Сургуульд суралцсан жил	Нэг хүнд ногдох ҮНО (2011 PPP \$)
Монгол Улс	0.735	69.7	14.2	10.2	10 784
Зүүн Ази, номхон далайн орнууд	0.741	75.3	13.4	7.9	14 611
ХХИ нэн өндөр орнууд	0.892	79.5	16.4	12.0	40 112
ХХИ өндөр орнууд	0.750	75.1	13.8	8.3	14 403
ХХИ дундаж орнууд	0.634	69.3	11.7	6.4	6 240

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД

Тус бүлэгт Дэлхийн банкнаас (ДБ) эрхлэн гаргадаг “Дэлхийн хөгжлийн үзүүлэлт”-2019, НҮБХХ-өөс эрхлэн гаргадаг “Хүний хөгжлийн илтгэл”-2019 зэрэг баримт бичигт тусгагдсан эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтийн 2010-2019 оны мэдээллийг ашиглав.

Дэлхийн банкнаас жил бүр улс, орнуудыг нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын хэмжээнээс нь хамааруулан бага орлоготой, дунд орлоготой (дундаас доогуур болон дундаас дээгүүр), өндөр орлоготой гэж ангилдаг.

Дэлхийн банкны атласын аргаар тооцсон нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээ нь 2019 оны байдлаар 1035 ам.доллараос бага бол бага орлоготой (low income), 1036 ам.доллараос 4045 ам.долларын хооронд бол дундаас доогуур орлоготой (lower middle income), 4046 ам. доллароос 12535 ам.долларын хооронд бол дундаас дээгүүр орлоготой (upper middle income), 12536 ам.доллараос их бол өндөр орлоготой (high income) гэсэн 4 ангилалд хуваасан байна. Манай улс 2014 онд дундаас дээш орлоготой орны тоонд багтсан боловч 2015 оноос хойш дундаас доогуур орлоготой орны ангилалд хамаарч байна.


Түүнчлэн Дэлхийн банкнаас дээрх орлогын ангиллаас гадна бүс нутгийн орлогын ангиллаар дэлхийн улс орнуудыг 7 бүсэд ангилдаг. Монгол Улс Зүүн Ази, Номхон далайн орнуудын ангилалд хамаардаг.

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг олон улсын түвшинд харьцуулахын тулд манай улстай нэг хүнд ногдох ҮНО-р ижил түвшний улсыг сонгож авсан. Ингэхдээ

- бүс нутгийн орлогын ангилал,
- нэг хүнд ногдох ҮНО-ын (ДБ-ны атласын аргаар тооцсон) хэмжээ,
- хүний хөгжлийн индекс (ХХИ)

зэрэг үзүүлэлтээр ижил түвшинд байгаа улсуудыг сонгосон. Мөн нэмэлтээр манай улсын хөрш болох ОХУ, БНХАУ-тай харьцуулсан.

Зураг 6. Нэг хүнд ногдох ҮНО-оор болон ХХИ-ээр эзлэх байр, 2019 он



2.1. НЭГ ХҮНД НОГДОХ ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО

ДБ-ны тооцооллоор 2019 онд дэлхийн хэмжээнд нийт 88.8 их наяд ам.долларын бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэсэн байна. Үүний 55.9 их наяд ам.доллар буюу 63.0 хувийг дэлхийн нийт хүн амын 16.1 хувь амьдардаг өндөр орлоготой орнууд, 32.8 их наяд ам.доллар буюу 37.0 хувийг нийт хүн амын 83.9 хувь амьдардаг дунд орлоготой орнууд бүрдүүлжээ.

Монгол Улсын ҮНО 2019 онд 12.1 тэрбум ам.доллар болж, 2010 оноос 6.7 (2.2 дахин) тэрбум ам.доллар, 2018 оноос 0.6 (5.2%) тэрбум ам.доллаароор өссөн байна. Индонези улсын ҮНО 2019 онд 1.1 их наяд ам.доллар болж, 2010 оноос 485.0 (79.2%) тэрбум ам.доллаароор, 2018 оноос 68.0 (6.6%) тэрбум ам.доллаароор өссөн байна. Филиппин Улсын ҮНО 2019 онд 415.7 тэрбум ам.доллар болж, 2010 оноос 193.0 (86.7%) тэрбум ам.доллар, 2018 оноос 20.5 (5.2%) тэрбум ам.доллаароор өссөн байна. ОХУ-ын ҮНО 2019 онд 1.7 их наяд ам.доллар болж, 2010 оноос 226.4 (15.9%) тэрбум ам.доллаароор, 2018 оноос 146.7 (9.7%) тэрбум ам.доллаароор өссөн байна. БНХАУ-ын ҮНО 2019 онд 15.6 их наяд ам.доллар болж, 2010 оноос 8.7 (2.5 дахин) их наяд ам.доллаароор, 2018 оноос 1.2 (8.7%) их наяд ам.доллаароор өссөн байна.

Өнгөрсөн арван жилийн хугацаанд Монгол Улсын ҮНО жилд дунджаар 9.3 хувиар өсөж байсан нь дэлхийн дундаж өсөлтөөс 5.8 пунктээр, бага, дунд орлоготой орнуудаас 3.1 пунктээр, Индонези улсаас 2.6 пунктээр, Филиппин улсаас 2.1 пунктээр, ОХУ-аас 7.7 пунктээр хурдан өссөн байна. Харин ЗАНДБН-ын орнуудын (өндөр орлоготой орнуудыг хассанаар) ҮНО-ын дундаж өсөлтөөс 1.4 пунктээр, БНХАУ-аас 1.4 пунктээр удаан байсан байна.

Хүснэгт 3. Үндэсний нийт орлого, тэрбум ам.доллар, 2010-2019 он

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
ДЭЛХИЙ	65 206.1	69 396.4	74 432.9	78 034.5	79 836.3	78 326.9	77 305.0	78 674.8	84 724.9	88 781.5
Бага, дунд орлоготой орнууд	19 023.0	21 424.9	24 578.9	26 927.2	28 206.0	27 855.6	27 647.0	28 470.8	30 844.5	32 843.9
Бага орлоготой орнууд	368.6	389.1	423.1	460.0	494.6	500.8	501.1	498.8	507.9	529.2
Дундаж орлоготой орнууд	18 659.9	21 034.3	24 148.5	26 458.4	27 705.2	27 351.4	27 143.5	27 965.6	30 323.0	32 297.1
Монгол	5.4	7.2	10.3	12.5	12.4	11.5	10.7	10.1	11.5	12.1
Индонези	612.2	737.7	889.2	939.7	922.9	886.5	890.4	934.2	1 029.2	1 097.2
Филиппин	222.7	240.9	278.2	312.6	334.2	345.5	357.9	371.4	395.2	415.7
ОХУ	1 425.1	1 581.3	1 931.7	2 179.4	2 137.9	1 725.2	1 426.9	1 352.3	1 504.8	1 651.5
БНХАУ	5 801.8	6 783.8	8 005.8	9 193.8	10 246.6	10 894.0	11 398.8	12 111.1	13 394.9	14 554.3
Зүүн Ази, Номхон далайн орнууд (өндөр орлоготой орнуудыг хассанаар)	7 389.4	8 596.3	10 120.6	11 466.0	12 567.0	13 191.4	13 717.2	14 514.7	16 027.7	17 375.8
Европ, Төв Ази (өндөр орлоготой орнуудыг хассанаар)	2 792.4	3 061.8	3 556.1	3 955.3	3 943.9	3 431.2	2 996.2	2 881.9	3 050.4	3 200.9
Өмнөд Азийн орнууд	1 889.9	2 132.6	2 353.2	2 464.5	2 573.1	2 686.2	2 859.4	3 131.1	3 475.3	3 705.6

Манай улсын ҮНО дэлхийн ҮНО-ын 0.014 хувийг бүрдүүлж байгаа бол бага, дунд орлоготой орнуудын ҮНО-ын 0.037 хувийг, ЗАНДБН-ын орнуудын (өндөр орлоготой орнуудыг хассанаар) ҮНО-ын 0.07 хувийг бүрдүүлж байна.

Дэлхийн нэг хүнд ногдох үндэсний нийт орлого сүүлийн арван жилийн дунджаар 10397 ам.доллар, харин Монгол Улс багтдаг бага, дунд орлоготой орнуудын хувьд дунджаар 4314 ам.доллар байна. Хөгжлийн түвшингээр манай улстай ойролцоо улс, орнууд болох Индонези, Филиппин улсын нэг хүнд ногдох ҮНО дунджаар 3353 ам. доллар, 3188 ам.доллар байна. Манай улсын хөрш орнууд ОХУ болон БНХАУ-ын нэг хүнд ногдох ҮНО дунджаар 11892 ам. доллар болон 6795 ам. доллар байна.

Монгол Улсын нэг хүнд ногдох ҮНО 2019 онд 3780 ам.доллар болж, 2010 оноос 1780 (89.0%) ам.доллар, 2018 оноос 150 (4.1%) ам.доллороор өссөн байна. Индонези улсын нэг хүнд ногдох ҮНО 2019 онд 4050 ам.доллар болж, 2010 оноос 1520 (60.1%) ам.доллороор, 2018 оноос 200 (5.2%) ам.доллороор өссөн байна. Филиппин Улсын нэг хүнд ногдох ҮНО 2019 онд 3850 ам.доллар болж, 2010 оноос 1480 (62.4%) ам.доллар, 2018 оноос 140 (3.8%) ам.доллороор өссөн байна. ОХУ-ын нэг хүнд ногдох ҮНО 2019 онд 11260 ам.доллар болж, 2010 оноос 1280 (12.8%) ам.доллороор, 2018 оноос 1010 (9.9%) ам.доллороор өссөн байна. БНХАУ-ын нэг хүнд ногдох ҮНО 2019 онд 10410 ам.доллар болж, 2010 оноос 6070 (2.4 дахин) ам.доллороор, 2018 оноос 790 (8.2%) ам.доллороор өссөн байна.

Манай улсын нэг хүнд ногдох ҮНО 2019 онд дэлхийн дунджаас 3.1 дахин, Европ, Төв Азийн орнууд, Зүүн ази, Номхон далайн орнуудын дунджаас 2.1-2.2 дахин, хөрш хоёр орон ОХУ, БНХАУ-аас 2.8-3.0 дахин бага байна. Харин Өмнөд Азийн орнуудын дунджаас 87.3 хувиар их байна.


Хүснэгт 4. Нэг хүнд ногдох ҮНО, Дэлхийн банкны атласын аргаар, ам.доллар, 2010-2019 он

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
ДЭЛХИЙ	9 420.3	9 909.7	10 504.6	10 884.0	11 005.5	10 672.8	10 412.5	10 477.3	11 159.9	11 569.8
Бага, дунд орлоготой орнууд	3 312.8	3 682.4	4 170.0	4 509.5	4 663.1	4 546.6	4 455.4	4 530.7	4 848.7	5 101.8
Бага орлоготой орнууд	693.9	713.6	756.6	802.1	841.1	830.3	809.8	785.9	779.8	791.8
Дундаж орлоготой орнууд	3 580.7	3 989.2	4 526.5	4 901.8	5 073.6	4 951.9	4 858.8	4 950.3	5 310.4	5 598.2
Монгол	2 000.0	2 590.0	3 650.0	4 330.0	4 210.0	3 820.0	3 500.0	3 230.0	3 630.0	3 780.0
Индонези	2 530.0	3 010.0	3 580.0	3 730.0	3 620.0	3 430.0	3 400.0	3 530.0	3 850.0	4 050.0
Филиппин	2 370.0	2 520.0	2 860.0	3 160.0	3 330.0	3 380.0	3 450.0	3 530.0	3 710.0	3 850.0
ОХУ	9 980.0	11 060.0	13 490.0	15 190.0	14 630.0	11 780.0	9 730.0	9 210.0	10 250.0	11 260.0
БНХАУ	4 340.0	5 050.0	5 930.0	6 770.0	7 510.0	7 940.0	8 270.0	8 740.0	9 620.0	10 410.0
Зүүн Ази, Номхон далайн орнууд (өндөр орлоготой орнуудыг хассанаар)	3 758.7	4 341.5	5 074.6	5 707.6	6 210.2	6 472.1	6 681.2	7 018.3	7 699.3	8 299.2
Европ,Төв Ази (өндөр орлоготой орнуудыг хассанаар)	7 390.8	8 054.1	9 296.8	10 271.2	10 173.8	8 791.4	7 626.6	7 290.7	7 675.3	8 014.3
Өмнөд Азийн орнууд	1 153.3	1 283.6	1 397.6	1 444.8	1 489.4	1 535.5	1 614.4	1 746.5	1 915.4	2 018.6

Эх үүсвэр: “Дэлхийн хөгжлийн үзүүлэлт, 2019”, Дэлхийн банк

Монгол Улсын нэг хүнд ногдох ҮНО 2010 оноос хойш жилд дунджаар 7.3 хувиар өссөн нь дэлхийн дундаж өсөлтөөс 5.0 пунктээр, бага, дунд орлоготой орнуудаас 2.4 пунктээр, Индонези улсаас 2.0 пунктээр, Филиппин улсаас 1.8 пунктээр, ОХУ-аас 6.0 пунктээр их өссөн байна. Харин ЗАНДБН-ын орнуудын (өндөр орлоготой орнуудыг хассанаар) ҮНО-ын дундаж өсөлтөөс 1.9 пунктээр, БНХАУ-аас 2.9 пунктээр бага байна.

Зураг 7. Нэг хүнд ногдох ҮНО, Дэлхийн банкны атласын аргаар, ам.доллар, 2010-2019 он



Эх үүсвэр: “Дэлхийн хөгжлийн үзүүлэлт, 2019”, Дэлхийн банк


2.2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ, БҮТЭЦ

Дэлхийн санхүү эдийн засгийн хүндрэл, түүний дотор уул уурхай, олборлох салбарын түүхий эдийн үнийн уналт болон гадаадын шүүд хөрөнгө оруулалтын бууралт зэргээс шалтгаалж 2011 онд 17.3 хувийн өсөлттэй байсан Монгол Улсын эдийн засаг 2012-2016 онд 12.3-1.2 хувь хүртэл буурч байсан. Харин сүүлийн жилүүдэд эдийн засаг аажмаар сэргэн 2019 онд 5.1 хувь болж, 2016 оноос 3.9 пунктээр өссөн байна.

ДБ-ны 2019 оны тайлангаас харахад бага орлоготой орнуудын эдийн засаг тогтворгүй, нэлээд хэлбэлзэлтэй байгаа бол дундаас дээш орлоготой орнуудын эдийн засаг харьцангуй тогтвортой байгаа нь ажиглагдаж байна. Хэдийгээр Монгол Улс дундаж орлоготой орны тоонд багтдаг ч гэсэн уул уурхайгаас хэт хамааралтай учир эрдэс бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн савлагаанаас шалтгаалан эдийн засаг хэлбэлздэг.

Дэлхийн эдийн засаг 2019 онд 2.5 хувиар өссөн ч өсөлтийн хурд 2010 оноос 1.8 пунктээр, 2018 оноос 0.6 пунктээр саарсан байна. Сүүлийн арван жилийн хугацаанд дэлхий нийтээр эдийн засгийн өсөлт саарах үйл явц ажиглагдаж байна.

Зураг 8. ДНБ-ий жилийн өсөлт, бууралт, хувиар, 2010-2019 он



Эх үүсвэр: “Дэлхийн хөгжлийн үзүүлэлт, 2019”, Дэлхийн банк

Монгол Улсын хувьд 2010 оноос хойших арван жилд эдийн засгийн өсөлт жилд дунджаар 2.4 хувиар саарч байсан бол дэлхийн эдийн засгийн өсөлт жилд дунджаар 6.0 хувиар, бага, дунд орлоготой орнуудынх 6.8 хувиар, ЗАНДБН-ын орнуудынх 5.6 хувиар, Европ, Төв Азийн орнуудынх 12.5 хувь, Өмнөд Азийн орнуудынх 5.0 хувиар, Индонези улсынх 2.3 хувиар, Филиппин улсынх 2.1 хувиар, ОХУ-ынх 12.6 хувиар, БНХАУ-ынх 6.0 хувиар тус тус бүүрсан байна.

Хүснэгт 5. ДНБ-ий өсөлт, бууралт, хувиар, 2010-2019 он

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
ДЭЛХИЙ	4.3	3.1	2.5	2.7	2.8	2.9	2.6	3.3	3.1	2.5
Бага, дунд орлоготой орнууд	7.5	6.0	5.1	5.1	4.5	3.9	4.3	4.9	4.6	3.9
Бага орлоготой орнууд	5.8	3.3	2.3	5.7	5.0	2.1	3.9	4.4	3.6	3.9
Дундаж орлоготой орнууд	7.5	6.0	5.2	5.1	4.5	4.0	4.3	4.9	4.7	3.9
Монгол	6.4	17.3	12.3	11.6	7.9	2.4	1.2	5.3	7.2	5.1
Индонези	6.2	6.2	6.0	5.6	5.0	4.9	5.0	5.1	5.2	5.0
Филиппин	7.3	3.9	6.9	6.8	6.3	6.3	7.1	6.9	6.3	6.0
ОХУ	4.5	4.3	4.0	1.8	0.7	-2.0	0.2	1.8	2.5	1.3
БНХАУ	10.6	9.6	7.9	7.8	7.4	7.0	6.8	6.9	6.8	6.1
Зүүн Ази, Номхон далайн орнууд (өндөр орлоготой орнуудыг хассанаар)	9.8	8.5	7.5	7.2	6.9	6.6	6.5	6.6	6.5	5.8
Европ, Төв Ази (өндөр орлоготой орнуудыг хассанаар)	5.6	6.3	4.0	4.0	2.2	0.8	1.5	4.0	2.9	1.7
Өмнөд Азийн орнууд	7.7	5.1	5.5	6.1	7.0	7.5	7.8	6.8	6.1	4.8

ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЭЦ


Манай улс 2010 онд ДНБ-ий 44.8 хувийг үйлчилгээний салбар, 33.2 хувийг аж үйлдвэрийн салбар, 11.7 хувийг ХАА-н салбар, 10.2 хувийг бусад салбараас бүрдүүлсэн байна.

Монгол Улсын эдийн засгийн бүтцийг дэлхийн улсуудтай харьцуулбал, 2010 онд үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь дэлхийн эдийн засагт үйлчилгээний салбарын эзлэх хувиас 18.4 пунктээр, дундаж орлоготой орнуудаас 4.4 пунктээр бага байгаа бол бага орлоготой орнуудаас 5.6 пунктээр их байна.


Аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь 2010 онд дэлхийн эдийн засагт аж үйлдвэрийн салбарын эзлэх хувиас 6.0 пунктээр, бага орлоготой орнуудаас 8.1 пунктээр их байгаа бол дундаж орлоготой орнуудаас 2.8 пунктээр бага байна.

ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь 2010 онд дэлхийн эдийн засагт ХАА-н салбарын эзлэх хувиас 8.1 пунктээр, дундаж орлоготой орнуудаас 2.6 пунктээр их байгаа бол бага орлоготой орнуудаас 17.0 пунктээр бага байна.

Зураг 9. ДНБ-ий салбарын бүтэц, дүнд эзлэх хувиар, 2010 он



Зураг 10. ДНБ-ий салбарын бүтэц, дүнд эзлэх хувиар, 2019 он



Тайлбар: Аж үйлдвэрийн салбар дотор уул, уурхай, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан, дулаан, усан хангамж, барилгын салбар багтаж байна.

Харин манай улс 2019 онд ДНБ-ий 39.0 хувийг үйлчилгээний салбар, 39.1 хувийг аж үйлдвэрийн салбар, 11.0 хувийг ХАА-н салбар, 10.9 хувийг бусад салбараас бүрдүүлсэн байна. Энэ нь 2010 онтой харьцуулахад үйлчилгээний салбарын эзлэх хувь 5.8 пунктээр, ХАА-н салбарынх 0.7

пунктээр буурч, аж үйлдвэрийн салбарынх 5.9 пунктээр, бусад салбарынх 0.7 пунктээр өссөн байна.

Монгол Улсын 2019 оны эдийн засгийн бүтцийг дэлхийн улсуудтай харьцуулбал үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь дэлхийн эдийн засагт үйлчилгээний салбарын эзлэх хувиас 22.2 пунктээр, дундаж орлоготой орнуудаас 15.1 пунктээр бага байгаа бол бага орлоготой орнуудаас 1.3 пунктээр их байна.

Аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь 2019 онд дэлхийн эдийн засагт аж үйлдвэрийн салбарын эзлэх хувиас 11.3 пунктээр, дундаж орлоготой орнуудаас 7.0 пунктээр, бага орлоготой орнуудаас 12.3 пунктээр их байна.

ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь 2019 онд дэлхийн эдийн засагт ХАА-н салбарын эзлэх хувиас 7.0 пунктээр, дундаж орлоготой орнуудаас 3.2 пунктээр их байгаа бол бага орлоготой орнуудаас 12.3 пунктээр бага байна.

Улс орон хөгжихийн хирээр үйлчилгээний салбар хүрээгээ тэлж, ДНБ-д үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг (НӨ)-ийн эзлэх хувь нэмэгддэг бол Монгол Улсын хувьд үйлчилгээний салбарын цар хүрээ хумигдаж, 2019 онд ДНБ-д эзлэх хувь 39.0 хувь болж, 2010 оноос 5.8 пунктээр буурсан байна. Харин эсрэгээрээ ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 2019 онд 39.1 хувь болж, 2010 оноос 5.9 пунктээр нэмэгдсэн байна. Харин ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь 2019 онд 11.0 хувь болж, 2010 оноос 0.7 пунктээр буурсан байна.

Манай улсын эдийн засагт сүүлийн арван жилийн хугацаанд аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь нэмэгдсэн хэдий ч нөгөө талдаа аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээ нь уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэлээс ихээхэн хамаарах хандлагатай байна. Тухайлбал, аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, оны үнээр 2019 онд 2018 оноос 11.2 хувь буюу 3.0 их найд төгрөгөөр өсөхөд нийт өсөлтийн 54.7 хувь буюу 1.6 их наяд төгрөг нь уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэлийн хэмжээнээс хамаарсан байна.

Монгол Улсын боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ДНБ-д эзлэх хувь 2019 онд 9.6 хувь болж, 2010 оноос 2.8 пунктээр нэмэгдсэн байна. Бага, дунд орлоготой орнуудтай харьцуулахад боловсруулах салбарын ДНБ-д эзлэх хувь 2019 оны байдлаар 9.1 пунктээр бага байна.

ДНБ-ий өсөлт, салбарын бүтцийн өөрчлөлтийг хөгжлийн ижил түвшний улсуудтай болон хөрш орнуудтай харьцуулж үзье.


Манай улсын аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртгийн өсөлт 2019 оны байдлаар Индонези улсаас 0.9 пунктээр, Филиппин улсаас 1.8 пунктээр, БНХАУ-аас 2.8 пунктээр бага байгаа бол ОХУ-аас 1.9 пунктээр, дэлхийн дунджаас 0.8 пунктээр илүү байна.

Хөдөө аж, ахуйн салбарын нэмэгдэл өртгийн өсөлт 2019 онд Индонези улсаас 4.7 пунктээр, Филиппин улсаас 7.1 пунктээр, БНХАУ-аас 5.3 пунктээр, ОХУ-аас 7.7 пунктээр, дэлхийн дунджаас 6.0 пунктээр өндөр байна.

Үйлчилгээний салбарын нэмэгдэл өртгийн өсөлт 2019 онд Индонези улсаас 0.6 пунктээр, Филиппин улсаас 1.7 пунктээр, БНХАУ-аас 1.1 пунктээр доогуур байгаа бол ОХУ-аас 1.9 пунктээр их байна.

Зураг 11. Эдийн засгийн голлох салбарын НӨ-ийн өсөлт, бууралт, сонгогдсон улсаар, хувиар, 2010-2019 он






2.3. ИНФЛЯЦ

Манай улсын инфляцын жилийн дундаж түвшин 2019 онд 7.3 хувь болж, 2010 оноос 2.7 пунктээр буурч, 2018 оноос 0.5 пунктээр өссөн байна. Монгол Улсын 2019 оны инфляцын жилийн дундаж түвшинг дэлхийн инфляцтай харьцуулахад 3.2 дахин, дундаж орлоготой орнуудаас 2.6 дахин, бага орлоготой орнуудаас 2.5 дахин өндөр байна. МУ-ын инфляц 2010 онд дэлхийн инфляцаас 3.1 дахин, дундаж орлоготой орнуудаас 2.5 дахин, бага орлоготой орнуудаас 2.1 дахин өндөр байсан байна. Үүнээс дүгнэхэд манай улсын инфляцын түвшин сүүлийн арван жилийн хугацаанд нэлээд хэлбэлзэлтэй байсан ч буурах хандлага ажиглагдаж байна. Гэхдээ дэлхийн болон бага, дунд орлоготой орнуудын инфляцаас 2-3 дахин өндөр байсан хэвээр байна.


Зураг 12. Инфляцын түвшин, хувиар, 2010-2019 он



Манай улстай хөгжлийн түвшин ижил Индонези улсын хувьд 2019 онд инфляцын түвшин 3.0 хувь байгаа нь өмнөх оноос 0.2 пунктээр, 2010 оноос 2.1 пунктээр буурсан байна. Харин Филиппин улсын инфляцын түвшин 2019 онд 2.5 хувь болж, өмнөх оноос 2.7 пунктээр, 2010 оноос 1.3 пунктээр буурсан байна.

Манай улсын хөрш ОХУ болон БНХАУ-ын инфляцын түвшин 2019 онд 4.5 болон 2.9 хувь байгаа нь өмнөх онтой харьцуулахад ОХУ-ынх 1.6 пунктээр, БНХАУ-ынх 0.8 пунктээр тус тус өссөн байна. Харин 2010 онтой харьцуулахад ОХУ-ынх 2.4 пунктээр, БНХАУ-ынх 0.3 пунктээр тус тус буурсан байна.

Зураг 13. Инфляцын түвшин, сонгогдсон улсуудаар, хувиар, 2010-2019 он




2.4. УЛСЫН ТӨСӨВ, ГАДААД ӨР

Манай улсын төсвийн (тусламжийг оруулаагүй) орлогын ДНБ-д эзлэх хувь 2018 онд 28.7 болж, өмнөх оноос 3.7 пунктээр нэмэгдэж, 2010 оноос 0.3 пунктээр буурсан байна. МУ-ын төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь 2018 оны дэлхийн улсуудын төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувиас 4.1 пунктээр, Индонези улсаас 15.7 пунктээр, Филиппин улсаас 13.1 пунктээр их байна.

Дэлхийн улс орнуудын төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь 2010 оноос хойш жилд дунджаар 1.1 хувиар нэмэгдэж байгаа бол Монгол Улсын төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь 0.1 хувиар буурч байна.


Зураг 14. Улсын төсвийн орлогын (тусламжийг оруулаагүй) ДНБ-д эзлэх хувь, 2010-2018 он



МУ-ын улсын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 2018 онд 11.7 болж, өмнөх оноос 1.1 пунктээр, 2010 оноос 1.0 пунктээр буурсан байна. МУ-ын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 2018 оны дэлхийн улсуудын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувиас 5.4 пунктээр, Филиппин улсаас 0.3 пунктээр бага байгаа бол Индонези улсаас 2.7 пунктээр их байна.

Дэлхийн улс орнуудын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 2010 оноос хойш жилд дунджаар 0.4 хувиар буурсан байна. Монгол Улсын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь мөн 0.9 хувиар буурч байна.

Зураг 15. Улсын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь, 2010-2018 он



Манай улсын хувьд төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь буурч байгаа ч эдийн засаг дахь төрийн оролцоо багасаж байгааг илтгэж чадахгүй байна. Учир нь манай улсын төсвөөс гадуурх зардал өндөр байгаа ба Засгийн газрын бондын ихээхэн хувийг төсвөөс гадуурх хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд ашиглаж байна. Төсвөөс гадуурх зарлага гэдэг нь Засгийн газрын зарлага боловч эдгээр нь албан ёсны төсөвт бүртгэгдээгүй зарлагаар тодорхойлогдоно.²

Гадаад өрийн хэмжээ нь тухайн улсын зээлжих зэрэглэл болон хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад нөлөөлдөг гол үзүүлэлт юм. Хөгжиж буй орнуудын туршлагаар зээлийн хэмжээний өнөөгийн утга нь нийт экспортын 200 хувьд хүрэхэд өр төлбөрийн хүндрэл үүсдэг болох нь тогтоогдсон байна.³

Өрийн асуудал нь Монгол Улс төдийгүй бусад улс орны хувьд ч өндөр өсөлттэй байна. Бага, дунд орлоготой улс орнуудын гадаад өрийн хэмжээ 2010 онд 4.4 их наяд ам.доллар байсан бол 2018 онд 77.1 хувиар өсөж, 7.8 их наяд ам.доллар болсон байна. Монгол Улсын хувьд сүүлийн 10 жилийн хугацаанд 5 дахин нэмэгдэж 2018 байдлаар 29.4 тэрбум ам.долларын өрийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 6. Гадаад өрийн хэмжээ, тэрбум ам.доллар, 2010-2018 он

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Бага, дунд орлоготой орнуудын дундаж	4 414.2	5 177.9	5 730.3	6 508.0	6 939.9	6 454.7	6 725.2	7 426.8	7 819.0
Бага орлоготой орнууд	82.0	85.4	91.6	108.1	117.2	124.3	130.0	144.8	150.3
Дундаж орлоготой орнууд	4 332.2	5 092.5	5 638.7	6 399.9	6 822.6	6 330.4	6 595.2	7 282.0	7 668.8
Монгол	5.9	9.6	15.6	19.2	21.2	21.9	25.7	28.8	29.4
Индонези	198.3	219.6	252.6	263.6	292.6	307.8	319.0	353.7	379.7
Филиппин	65.4	66.1	69.4	66.2	77.2	76.5	72.9	74.4	78.8
ОХУ	417.9	544.3	591.8	668.5	549.6	467.7	533.2	518.2	453.9
БНХАУ	734.6	1 044.5	1 138.4	1 471.7	1 770.5	1 325.9	1 415.8	1 709.9	1 962.3
Зүүн Ази, Номхон далайн орнууд (өндөр орлоготой орнуудыг хассанаар)	1 183.4	1 546.3	1 728.0	2 090.8	2 434.5	1 999.3	2 115.6	2 489.0	2 791.5
Европ, Төв Ази (өндөр орлоготой орнуудыг хассанаар)	1 263.7	1 427.7	1 532.5	1 707.8	1 575.9	1 452.3	1 539.4	1 601.3	1 524.9
Өмнөд Азийн орнууд	410.0	460.5	528.3	566.2	604.5	635.6	624.5	707.2	730.1

Эх үүсвэр: Олон улсын гадаад өрийн статистик, Дэлхийн банк

Монгол Улсын үндэсний нийт орлого (ҮНО) болон гадаад өрийн үлдэгдлийн харьцаа 2018 оны байдлаар 253.9 хувь байсан нь бага, дунд орлоготой улс орнуудтай харьцуулахад 10 дахин өндөр

² [Монгол Улсын эдийн засгийн тойм, Дэлхийн банк](#)

³ [Олон улсын гадаад өрийн статистик, Дэлхийн банк](#)

үзүүлэлт юм. Харин Индонези улстай харьцуулахад 6.8 дахин, Филиппин улсаас 12.8 дахин, ОХУ-аас 9.0 дахин, БНХАУ-аас 17.5 дахин өндөр байна.

ОУВС-гийн эдийн засагч нар (2014)-ын тооцоолсноор цэвэр гадаад позиц болон ДНБ-ий харьцааны дээд хязгаар 49 хувь, нийт гадаад өр болон ДНБ-ий харьцааны дээд хязгаар 35 хувь байх нь зохистой түвшин гэж үзсэн байна.⁴

Аливаа улс оронд зохих түвшний өр байнга байдаг. Улс орон буурай хөгжилтэй орноос дунд түвшний орнуудын тоонд орохын тулд гаднын хөрөнгө оруулалт авах нь зүйн хэрэг юм. Тиймээс гадаадын шууд хөрөнгө оруулалт нь өр гэхээс илүүтэй эдийн засгийн хөгжлийг бий болгох санхүүжилт гэж ойлгож болно.

Гэвч Монгол Улсын гадаад өр болон ҮНО-ын харьцаа 2010 онд зохистой дээд хязгаараас 1.9 дахин өндөр байсан бол 2018 онд 7.3 дахин өндөр болж, нэмэгдсэн нь онцгой анхаарах асуудал юм.

Хүснэгт 7. ҮНО ба Гадаад өрийн харьцаа, хувиар, 2010-2018 он

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Бага, дунд орлоготой орнуудын дундаж	22.3	22.2	23.0	24.7	25.2	24.6	25.5	25.7	25.6
Бага орлоготой орнууд	24.8	23.0	22.2	24.2	24.4	26.1	27.7	29.0	27.8
Дундаж орлоготой орнууд	22.3	22.2	23.0	24.7	25.2	24.6	25.5	25.7	25.5
Монгол	89.7	100.8	137.2	161.6	188.7	203.4	250.7	292.9	253.9
Индонези	27.0	25.3	28.3	29.8	34.0	37.0	35.4	36.0	37.6
Филиппин	27.2	24.6	23.0	20.0	22.4	21.6	19.9	19.7	19.9
ОХУ	28.3	27.3	27.6	30.1	27.6	35.3	42.8	33.7	28.1
БНХАУ	12.1	14.0	13.4	15.5	16.9	12.1	12.8	14.1	14.5
Зүүн Ази, Номхон далайн орнууд (өндөр орлоготой орнуудыг хассанаар)	15.6	16.8	16.7	18.4	19.7	15.6	16.2	17.5	17.6
Европ, Төв Ази (өндөр орлоготой орнуудыг хассанаар)	41.9	38.4	38.9	40.8	40.1	48.1	53.3	49.5	46.1
Өмнөд Азийн орнууд	19.9	20.2	23.0	24.0	23.4	23.5	21.4	21.1	21.1

Эх үүсвэр: Олон улсын гадаад өрийн статистик, Дэлхийн банк


Монгол Улсын экспорт болон гадаад өрийн харьцаа 2018 оны байдлаар 370.0 хувь байсан нь бага, дунд орлоготой улс орнуудтай харьцуулахад 3.7 дахин өндөр байна. Харин Индонези улстай харьцуулахад 2.1 дахин, Филиппин улсаас 4.8 дахин, ОХУ-аас 4.6 дахин, БНХАУ-аас 5.4 дахин өндөр байна.

Манай улсын экспорт болон гадаад өрийн харьцаа 2010 онд 128.5 хувь байсан бол 2018 онд 2.1 дахин нэмэгдэж 370.0 хувь болсон байна. Индонези улсын экспорт болон гадаад өрийн харьцаа 2018 онд 2010 оноос 48.1 хувиар өсөж, 174.2 хувь, БНХАУ-ынх 61.6 хувиар өсөж, 68.0 хувь болсон

⁴ [“Төлбөрийн Тэнцэл ба Гадаад өр” онол практикийн бага хурал, илтгэл №2](#)

байна. Харин Филиппин улсынх 27.0 хувиар, ОХУ-ынх 7.0 хувиар буурч, тус тус 77.9 хувь, 81.0 хувь болсон байна.

Зураг 16. Гадаад өр ба экспортын харьцаа, хувиар, 2010-2018 он




2.5. ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2019 онд нийт 152 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 13.7 тэрбум америк доллар, үүнээс экспорт 7.6 тэрбум америк доллар, импорт 6.1 тэрбум америк долларт хүрсэн байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 860.6 (6.7%) сая америк доллар, үүнээс экспорт 608.0 (8.7%) сая америк доллароор, импорт 252.6 (8.0%) сая америк доллароор тус тус өссөн байна. Харин 2010 оноос 7.6 (2.3 дахин) тэрбум америк доллар, үүнээс экспорт 4.7 (2.6 дахин) тэрбум америк доллароор, импорт 2.9 (1.9 дахин) тэрбум америк доллароор тус тус өссөн байна.

Монгол Улсын гадаад худалдааны эргэлт сүүлийн арван жилд үнийн дүнгээрээ 2 дахин өсөхөд боловсруулах үйлдвэрлэлийн сэргэлт, гадаад зах зээл дээрх уул уурхай, олборлох салбарын түүхий эдийн үнийн өсөлт эерэг нөлөөлсөн байна.

Зураг 17. Монгол Улсын экспорт, импорт, тэнцэл, тэрбум америк доллароор, 2010-2019 он



Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2014 оноос эхлэн ашигтай гарч эхэлсэн бөгөөд 2019 онд ашгийн хэмжээ 1.5 тэрбум ам.долларт хүрч 2010 оноос 1.8 тэрбум америк доллароор (6.1 дахин), өмнөх оноос 355.2 сая америк доллароор (31.2%) өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарахад эрдэс бүтээгдэхүүн буюу уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн тэр дундаа нүүрсний экспортын хэмжээ өссөн нь голлох нөлөөг үзүүлж байгаа бол дизелийн түлш болон ачааны тэрэгний импортын өсөлт ашгийн хэмжээг бууруулжээ.

Ази тивийн улсуудтай 2010 онд нийт гадаад худалдааны бараа эргэлтийн 66.5 хувийг, Европ тивийн улсуудтай 26.8 хувийг, Америк тивийн улсуудтай 5.7 хувийг, Африк тивтэй 0.2 хувийг, Австрали тивтэй 0.8 хувийг хийж байсан бол 2019 оны байдлаар нийт гадаад худалдааны бараа эргэлтийн 74.5 хувийг Ази тивийн улсуудтай, 21.6 хувийг Европ тивийн улсуудтай, 3.1 хувийг Америк тивийн улсуудтай, 0.1 хувийг Африк тивтэй, 0.8 хувийг Австрали тивийн улсуудтай хийсэн байна.

Сүүлийн арван жилийн хугацаанд Ази тивийн улсуудтай хийх худалдаа 2.5 дахин нэмэгдэж, 10.2 тэрбум ам.доллар болсон байна. Үүнд БНХАУ-тай хийсэн худалдаа 2.6 дахин нэмэгдэж 8.9 тэрбум ам.доллар болсон нь голлон нөлөөлсөн байна.

Манай хөрш хоёр улс нь гадаад худалдааны нийт эргэлтэд хамгийн өндөр дүнг эзэлж байгаа бөгөөд 2019 онд ОХУ-тай 1.8 тэрбум ам.доллар (13.1%), БНХАУ-тай 8.9 тэрбум ам.долларын (64.4%) худалдааг хийжээ. 2010 онтой харьцуулахад ОХУ-тай хийсэн бараа эргэлт нийт гадаад худалдааны бараа эргэлийн дүнд эзлэх хувь 5.4 пунктээр буурсан бол, БНХАУ-тай хийсэн бараа эргэлт 8.0 пунктээр нэмэгдсэн байна.

Нийт экспорт 2010 онд 2.9 тэрбум ам.доллар байсан бол 2019 онд 7.6 тэрбум ам.доллар болж, 4.7 (2.6 дахин) тэрбум ам.доллароор өсжээ. Экспортын бүтцийг тивээр харвал 2019 онд Ази тив 92.4 хувь, Европ тив 6.7 хувь, Америк тив 0.4 хувь, Австрали тив 0.5 хувийг эзэлж байна. Энэ нь 2010 оноос Ази тивийн эзлэх хувь 5.1 пунктээр, Австрали тивийн эзлэх хувь 0.5 пунктээр нэмэгдсэн бол Европ тивийн эзлэх хувь 0.8 пунктээр, Америк тивийн эзлэх хувь 4.8 пунктээр буурсан байна.

Нийт экспортод БНХАУ-ын эзлэх хувь 2019 онд 89.1 болж, 2010 оноос 4.3 пунктээр нэмэгдсэн бол ОХУ-ын эзлэх хувь 0.9 болж, 2.0 пунктээр буурсан байна.

Нийт импорт 2010 онд 3.2 тэрбум ам.доллар байсан бол 2019 онд 6.1 тэрбум ам.доллар болж, 2.9 (91.5%) тэрбум ам.доллароор өсжээ. Импортын бүтцийг тивээр харвал 2019 онд Ази тив 52.2 хувь, Европ тив 40.1 хувь, Америк тив 6.4 хувь, Африк тив 0.2 хувь, Австрали тив 1.1 хувийг эзэлж байна. Энэ нь 2010 оноос Ази тивийн эзлэх хувь 4.7 пунктээр, Америк тивийн эзлэх хувь 0.2 пунктээр нэмэгдсэн бол Европ тивийн эзлэх хувь 4.3 пунктээр, Африк тивийн эзлэх хувь 0.1 пунктээр, Австрали тивийн эзлэх хувь 0.4 пунктээр буурсан байна.

Нийт импортод БНХАУ-ын эзлэх хувь 2019 онд 33.6 болж, 2010 оноос 3.1 пунктээр нэмэгдсэн бол ОХУ-ын эзлэх хувь 28.2 болж, 4.5 пунктээр буурсан байна.

Хүснэгт 8. Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт, импорт, экспорт, тив, улс орноор, сая ам.доллар, 2010-2019 он


Тив	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Нийт эргэлт	6 108.6	11 415.9	11 123.0	10 626.9	11 011.0	8 466.8	8 274.5	10 537.9	12 886.6	13 747.1
Ази	4 060.2	7 696.0	7 258.9	6 862.5	7 914.7	6 181.5	5 765.7	7 610.9	9 763.5	10 239.4
Европ	1 639.6	2 787.7	2 960.4	2 912.7	2 762.8	2 081.9	2 278.2	2 591.8	2 756.0	2 966.6
Америк	349.2	805.0	794.8	756.8	285.4	173.8	194.0	280.9	295.9	421.4
Африк	9.9	15.3	8.1	16.4	11.8	5.7	4.8	6.9	12.4	11.1
Австрали	49.6	111.8	100.9	78.5	36.3	23.9	31.9	47.4	58.7	108.7
Индонези	6.4	11.7	19.8	17.6	15.6	13.5	15.6	17.8	18.1	21.3
ОХУ	1 129.4	1 721.0	1 927.0	1 623.6	1 610.9	1 097.9	936.2	1 286.8	1 796.3	1 798.0
БНХАУ	3 442.7	6 472.7	5 933.1	5 528.9	6 841.3	5 300.1	4 962.8	6 735.2	8 537.6	8 850.5
Экспорт	2 908.5	4 817.5	4 384.7	4 269.1	5 774.3	4 669.3	4 916.3	6 200.6	7 011.8	7 619.6
Ази	2 540.4	4 506.0	4 103.1	3 758.3	5 161.8	4 055.1	3 965.4	5 386.6	6 653.1	7 041.5
Европ	217.4	212.1	157.0	358.6	593.8	590.7	934.3	798.9	346.6	509.0
Америк	149.9	98.5	122.0	141.1	16.5	20.4	14.4	11.0	10.4	27.7
Африк	0.5	0.5	2.0	2.7	1.0	0.0	1.1	0.6	0.3	1.7
Австрали	0.3	0.5	0.6	8.3	1.2	3.1	1.3	3.5	1.3	39.7
Индонези	-	-	0	0.1	0.1	1.7	3.8	3.3	0.2	0
Филиппин	0.2	0	0	2.5	0.8	0.9	0.2	0	2.2	0
ОХУ	82.7	96.3	79.6	61.8	61.6	76.9	55.8	67.7	85.9	68.1
БНХАУ	2 466.4	4 439.9	4 059.7	3 706.3	5 073.4	3 910.1	3 901.6	5 307.4	6 542.8	6 789.7
Импорт	3 200.1	6 598.4	6 738.4	6 357.8	5 236.7	3 797.5	3 358.1	4 337.3	5 874.8	6 127.5
Ази	1 519.8	3 190.1	3 155.9	3 104.2	2 752.9	2 126.4	1 800.3	2 224.3	3 110.4	3 197.8
Европ	1 422.2	2 575.6	2 803.4	2 554.1	2 169.0	1 491.2	1 343.9	1 792.9	2 409.4	2 457.5
Америк	199.3	706.5	672.8	615.6	268.8	153.4	179.6	269.9	285.5	393.7
Африк	9.5	14.8	6.1	13.7	10.7	5.7	3.8	6.4	12.1	9.4
Австрали	49.3	111.3	100.2	70.2	35.2	20.8	30.6	43.9	57.4	69.0
Индонези	6.4	11.7	19.8	17.5	15.5	11.8	11.8	14.4	17.9	21.3
ОХУ	1 046.7	1 624.7	1 847.4	1 561.9	1 549.3	1 021.0	880.4	1 219.2	1 710.3	1 729.9
БНХАУ	976.2	2 032.9	1 873.4	1 822.6	1 767.9	1 389.9	1 061.2	1 427.7	1 968.8	2 060.8

Манай улс Дэлхийн Худалдааны Байгууллагын (ДХБ) бүс нутгийн эдийн засгийн интеграцийн дэлхийн газрын зурагт 2016 оныг хүртэл цагаан өнгөөр будагдаж байсан цөөхөн хэдэн орны нэг байсан бөгөөд хэлэлцээр хэрэгжүүлж буй байдлаараа бусад улс орнуудтай харьцуулахад хангалтгүй хэвээр байна.

Дэлхийн улс орнууд чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ), гаалийн холбоо байгуулах замаар худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааг явуулж, энэ нь олон талт худалдааны тогтолцооны дараа орох худалдааны бодлогын арга хэрэгсэл болж, ЧХХ-ийг ашиглан гадаадын шүүд хөрөнгө оруулалтыг татах, үйлдвэрлэлтийн зориулалттай тоног төхөөрөмж, түүхий эд нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, шинэ ажлын байрыг бий болгох, дэвшилтэт технологийг дамжуулан авах зэрэг

эдийн засгийн олон салбарт дэмжлэг болно хэмээн үзэж сүүлийн жилүүдэд нэлээд эрчимтэй хөгжүүлж байгаа юм.

Зураг 17. Бүс нутгийн эдийн засгийн интеграцийн дэлхийн газрын зураг, 2020 он




Эх үүсвэр: [ДХБ, Бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн оролцоо](#)

Монгол Улсын хувьд гадаад худалдааны бодлогыг Гадаад Харилцааны Яам боловсруулж, хэрэгжүүлж байгаа бөгөөд БНСУ-тай ЧХХ-ээр хийх боломжийн талаар судалгааны ажлыг хийж дуусган, хэлэлцээрийг эхлүүлэхэд бэлэн болсон байна. Мөн БНХАУ-тай ЧХХ хийх боломжийг судалж эхэлжээ.

Япон Улс манай орны худалдааны 3 дахь том түнш улс болсон бөгөөд Монгол Улс 2016 оны 6 дугаар сарын 7-нд Эдийн засгийн түншлэлийн буюу анхны чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулсан. Энэхүү Монгол, Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд Монгол Улс 97 бүлгийн 5700 орчим төрлийн бараа, Япон Улс 97 бүлгийн 9300 орчим төрлийн барааны импортын гаалийн тарифын заримыг чөлөөлж, нөгөө хэсгийг нь үе шаттайгаар бууруулахаар болсон билээ.

Улс орнууд гаалийн тарифаа аажмаар буулгаж зах зээлээ нээж байгаа хэдий ч ялангуяа өндөр хөгжилтэй орнуудын зах зээл тариф бус механизм буюу стандарт, техникийн нөхцөлөөр зах зээлээ хамгаалах хандлага элбэг байна. Иймд энэ асуудлыг ЧХХ, Гаалийн Холбоо байгуулах замаар тариф болон тарифын бус хориг саадыг хэлэлцээ хийж, тохиролцох үйл явц бүс нутгийн хэмжээнд эрчимтэй явагдаж байна.

Зураг 18. ХАА-н бараа, бүтээгдэхүүний тариф, улсаар 2017 он



Зарим улс орнууд дотоод үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс ДХБ-ын хүрээнд зөвшөөрөгдсөн хэмжээнд тарифыг нэмэгдүүлэх боломжтой байдаг. Гэхдээ энэ арга хэмжээ нь зах зээлээ хаах, худалдаанд саад болох зорилгоор хэрэглэж болохгүй гэсэн зарчим үйлчилж байна.

Зураг 19. Аж үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний тариф, улсаар 2017 он



ДҮГНЭЛТ

Монгол Улсын нэг хүнд ногдох ҮНО 2019 оны байдлаар 3780 ам.доллар болж, дэлхийд 124 дүгээрт, ХХИ-ээрээ 92-т эрэмбэлэгдэж байна.

Монгол Улс дэлхийн банкнаас гаргадаг орлогын ангиллаар дундаас доогуур орлоготой орны тоонд хамаарч байгаа ч, НҮБХХ-ын ангиллаар хүний хөгжлөөр өндөр түвшний орнуудын ангилалд багтаж байна.

- ✓ НҮБХХ-өөс гаргасан тооцоогоор манай улсын ХХИ 2018 онд 0.735 нэгж болж, дэлхийн ХХИ-ээс 0.004 нэгжээр өндөр байгаа бол хүний хөгжлөөр нэн өндөр үзүүлэлттэй орнуудын дунджаас 0.157 нэгжээр доогуур байна.
 - Монгол хүний дундаж наслалт 2018 оны байдлаар 69.7 жил байгаа нь хүний хөгжлийн нэн өндөр үзүүлэлттэй орнуудаас 9.8 жилээр бага, хүний хөгжлийн дундаж үзүүлэлттэй орнуудаас 0.4 жилээр их байна.
 - Сургуульд суралцах дундаж хугацаа 14.2 жил байгаа нь хүний хөгжлийн дундаж үзүүлэлттэй орнуудаас 2.5 жилээр илүү, хүний хөгжлийн нэн өндөр үзүүлэлттэй орнуудаас 2.2 жилээр бага байна.
 - Харин сургуульд суралцсан дундаж жил 10.2 жил байгаа нь хүний хөгжлийн дундаж үзүүлэлттэй орнуудаас 3.8 жилээр илүү, хүний хөгжлийн нэн өндөр үзүүлэлттэй орнуудаас 1.8 жилээр бага байна.
 - Хүний хөгжлийн гол үзүүлэлтүүдийн нэг болох нэг хүнд ногдох ҮНО (2011 оны худалдан авах чадварын паритетаар тооцсон) 2018 онд 10784 ам.доллар болж өнгөрсөн жилээс 6.7 хувиар өссөн хэдий ч хүний хөгжлөөр ижил бүлгийн орнуудаас 25.1 хувиар, хүний хөгжлөөр нэн өндөр орнуудаас 3.7 дахин бага орлоготой байна.
- ✓ Өнгөрсөн арван жилийн хугацаанд Монгол Улсын ҮНО жилд дунджаар 9.3 хувиар өсөж байсан нь дэлхийн дундаж өсөлтөөс 5.8 пунктээр, бага, дунд орлоготой орнуудаас 3.1 пунктээр, ОХУ-аас 7.7 пунктээр хурдан өссөн байна. Харин БНХАУ-аас 1.4 пунктээр удаан байсан байна.
- ✓ Дэлхийн санхүү эдийн засгийн хүндрэл, түүний дотор уул уурхай, олборлох салбарын түүхий эдийн үнийн уналт болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралт зэргээс шалтгаалж 2011 онд 17.3 хувийн өсөлттэй байсан Монгол Улсын эдийн засаг 2012-2016 онд 12.3-1.2 хувь хүртэл буурч байсан. Харин сүүлийн жилүүдэд эдийн засаг аажмаар сэргэн 2019 онд 5.1 хувь болж, 2016 оноос 3.9 пунктээр өссөн байна.
 - Манай улс 2010 онд ДНБ-ий 44.8 хувийг үйлчилгээний салбар, 33.2 хувийг аж үйлдвэрийн салбар, 11.7 хувийг ХАА-н салбар, үлдсэн 10.2 хувийг бусад салбараас бүрдүүлж байсан бол 2019 онд ДНБ-ий 39.0 хувийг үйлчилгээний салбар, 39.1 хувийг аж үйлдвэрийн салбар, 11.0 хувийг ХАА-н салбар, үлдсэн 10.9 хувийг бусад салбараас бүрдүүлж байжээ.

- Улс орон хөгжихийн хирээр үйлчилгээний салбар хүрээгээ тэлж, ДНБ-д үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг (НӨ)-ийн эзлэх хувь нэмэгддэг бол Монгол Улсын хувьд үйлчилгээний салбарын цар хүрээ хумигдаж, 2019 онд ДНБ-д эзлэх хувь 39.0 хувь болж, 2010 оноос 5.8 пунктээр буурсан байна. Харин эсрэгээрээ ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 2019 онд 39.1 хувь болж, 2010 оноос 5.9 пунктээр нэмэгдсэн байна. Харин ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь 2019 онд 11.0 хувь болж, 2010 оноос 0.7 пунктээр буурсан байна.
- Манай улсын эдийн засаг сүүлийн арван жилийн хугацаанд илүү аж үйлдвэржиж байна гэж хэлж болох ч нөгөө талдаа аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээ нь уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэлээс ихээхэн хамаарах хандлагатай байна.
- ✓ Монгол Улсын 2019 оны инфляцын жилийн дундаж түвшинг дэлхийн инфляцтай харьцуулахад 3.2 дахин, дундаж орлоготой орнуудаас 2.6 дахин, бага орлоготой орнуудаас 2.5 дахин өндөр байна. 2010 онд МУ-ын инфляц дэлхийн инфляцаас 3.1 дахин, дундаж орлоготой орнуудаас 2.5 дахин, бага орлоготой орнуудаас 2.1 дахин өндөр байсан байна. Үүнээс дүгнэхэд манай улсын инфляцын түвшин сүүлийн арван жилийн хугацаанд нэлээд хэлбэлзэлтэй байсан ч буурах хандлага ажиглагдаж байна. Гэхдээ дэлхийн болон бага, дунд орлоготой орнуудын инфляцаас 2-3 дахин өндөр байсан хэвээр байна.
- ✓ Гадаад өрийн хэмжээ нь тухайн улсын зээлжих зэрэглэл болон хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад нөлөөлдөг гол үзүүлэлт юм. Монгол Улсын хувьд буурай хөгжилтэй орноос дунд түвшний орнуудын тоонд орохын тулд гадны хөрөнгө оруулалт авах нь зүйн хэрэг боловч гадаад өрийг зохистой түвшинд барьж байх зайлшгүй шаардлагатай.
 - Бага, дунд орлоготой улс орнуудын гадаад өрийн хэмжээ 2010 онд 4.4 их наяд ам.доллар байсан бол 2018 онд 77.1 хувиар өсөж, 7.8 их наяд ам.доллар болсон байна. Манай улсын хувьд сүүлийн 10 жилийн хугацаанд 5 дахин нэмэгдэж 2018 байдлаар 29.4 тэрбум ам.долларын өрийн үлдэгдэлтэй байна.
 - Монгол Улсын гадаад өр болон ҮНО-ын харьцаа 2010 онд зохистой дээд хязгаараас 1.9 дахин өндөр байсан бол 2018 онд 7.3 дахин өндөр болж, нэмэгдсэн нь онцгой анхаарах асуудал юм.
- ✓ Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт сүүлийн арван жилд үнийн дүнгээрээ 2 дахин өсөхөд боловсруулах үйлдвэрлэлийн сэргэлт, гадаад зах зээл дээрх уул уурхай, олборлох салбарын түүхий эдийн үнийн өсөлт эерэг нөлөөлсөн байна.
 - Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2014 оноос эхлэн ашигтай гарч эхэлсэн бөгөөд 2019 онд ашгийн хэмжээ 1.5 тэрбум ам.долларт хүрч 2010 оноос 1.8 тэрбум америк доллароор (6.1 дахин), өмнөх оноос 355.2 сая америк доллароор (31.2%) өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарахад эрдэс бүтээгдэхүүн буюу уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн тэр дундаа нүүрсний экспортын хэмжээ өссөн нь голлох нөлөөг үзүүлж байгаа бол дизелийн түлш болон ачааны тэрэгний импортын өсөлт ашгийн хэмжээг бууруулжээ.
 - Манай хөрш хоёр улс нь гадаад худалдааны нийт эргэлтэд хамгийн өндөр дүнг эзэлж байгаа бөгөөд 2019 онд ОХУ-тай 1.8 тэрбум ам.доллар (13.1%), БНХАУ-тай 8.9 тэрбум

ам.долларын (64.4%) худалдааг хийжээ. 2010 онтой харьцуулахад ОХУ-тай хийсэн бараа эргэлт нийт гадаад худалдааны бараа эргэлийн дүнд эзлэх хувь 5.4 пунктээр буурсан бол, БНХАУ-тай хийсэн бараа эргэлт 8.0 пунктээр нэмэгдсэн байна.

- Нийт экспортод БНХАУ-ын эзлэх хувь 2019 онд 89.1 хувь болж, 2010 оноос 4.3 пунктээр нэмэгдсэн бол ОХУ-ын эзлэх хувь 0.9 хувь болж, 2.0 пунктээр буурсан байна.
 - Нийт импортод БНХАУ-ын эзлэх хувь 2019 онд 33.6 хувь болж, 2010 оноос 3.1 пунктээр нэмэгдсэн бол ОХУ-ын эзлэх хувь 28.2 хувь болж, 4.5 пунктээр буурсан байна.
- ✓ Манай улс Дэлхийн Худалдааны Байгууллагын (ДХБ) бүс нутгийн эдийн засгийн интеграцийн дэлхийн газрын зураг дээр 2016 оныг хүртэл цагаан өнгөөр будагдаж байсан цөөхөн хэдэн орны нэг байсан бөгөөд хэлэлцээр хэрэгжүүлж буй байдлаараа бусад улс орнуудтай харьцуулахад хангалтгүй хэвээр байна.